



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/283

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 2.4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол сумын “Баянгол омог”-ийн удам зүйн үнэлгээ, генетик тогтоцыг тодорхойлох судалгаанд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Судалгааг батлагдсан арга зүйн дагуу технологит хугацаанд явуулах ажлыг чанартай зохион байгуулж, үр дүнг нэгтгэн 2023 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0533

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 04-ны өдрийн 108 дугаар
захирамжийн хавсралт



БАЯНГОЛ СУМЫН "БАЯНГОЛ ОМГИЙН" ХОНИНЫ СУДАЛГААНЫ
АЖИЛ ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Төрөл	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт зардал
1.	Генетик тогтоцыг тодорхойлох	100	100,000	10,000,000
Нийт				10,000,000

-оОо-